



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/24

Төгөл

**Мал амьтны шилжилт хөдөлгөөн  
хориглох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, Аймгийн Засаг даргын 2024 оны А/61 дугаар захирамжийн 2,3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт мялзан өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулж гадна аймаг, сумаас орж ирэх мал амьтны хөдөлгөөнийг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 12 дүгээр сарын 01 –ний өдрийг хүртэл хориглосугай.

2. Мал эмнэлгийн үйлчилгээг эрс сайжруулж ажиллахыг "Буянт мал хөвсгөл" (Н.Тагнанжав) "Алаг хад далайц" (Г.Мөнхтуяа) "Хөгийн голын ундарга" (С.Жаргал) Бэлтэс ББН (М.Батцэнгэл) нарт, Халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мэргэжил арга зүйгээр хангаж судалгаа, тайланг бодитой чанартай гаргаж ажиллахыг Мал эмнэлгийн Тархвар зүйч (Н.Баярцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, сумын Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (Б.Баярмаа)-д хариуцуулсугай.

ДАРГА  Н.БАТБАЯР